

**ТӨСВИЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 10 дугаар сарын 07-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-19

<i>1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/</i>	<i>4-19</i>
---	-------------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан
10 дугаар сарын 07-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Х.Ганхуяг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 54 гишүүнээс 29 гишүүн хүрэлцэн ирж, 53.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 15 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Л.Соронзонболд;
Чөлөөтэй: Т.Аубакир, Ж.Батсуурь, П.Батчимэг, Х.Болормаа, Ж.Ганбаатар, Ц.Даваасүрэн, П.Сайнзориг, Д.Пүрэвдаваа, Б.Түвшин, Г.Тэмүүлэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Бат-Эрдэнэ, М.Энхцэцэг;
Тасалсан: Ч.Анар, Ц.Баатархүү, Н.Батсүмбэрэл, Б.Жаргалан, Б.Пунсалмаа, О.Цогтгэрэл.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрам, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа, Р.Рэнцэнбазар, А.Энхбат, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, мөн хэлтсийн шинжээч Ж.Өлзийсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал, Г.Нарантуяа, С.Төрмөнх, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Номин, Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсны Их Хурлын гишүүн

Да.Цогтбаатар, Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаа нар тус тус танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар, Да.Цогтбаатар, Ч.Номин, Х.Булгантуяа нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд дэх нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ 2026 онд “31,6 их наяд төгрөг” гэснийг “490 тэрбум” төгрөгөөр, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 2026 онд “32,9 их наяд төгрөг” гэснийг “490 тэрбум” төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, үүнтэй уялдуулан холбогдох эдийн засгийн үндсэн үзүүлэлт болон харгалзах дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээнд өөрчлөлт оруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэн үг хэлж, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам тайлбар хийв.

Зөвшөөрсөн:	1
Татгалзсан:	34
Бүгд:	35

2.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хороодын хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 54 минут үргэлжилж, ирвэл зохих 54 гишүүнээс 35 гишүүн хүрэлцэн ирж, 64.8 хувийн ирцтэйгээр 16 цаг 09 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Х.ГАНХУЯГ

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2025 оны 10 дугаар сарын 07-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
15 цаг 15 минут.*

ТӨСВИЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Х.Ганхуяг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 51,9 хувьтай бүрдсэн тул 2025 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн хамтарсан хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын, өнөөдрийн хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2027, 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Гишүүн байхгүй байна. Ажлын хэсгийг оруулъя. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027, 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан өнөөдрийн ажлын хэсэг, Ням-Осорын Учрал сайдыг дуудаарай. Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ренчинбазар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Батхүү Эдийн засгийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жигжидийн Ганбат ирээгүй байна уу, дуудаарай. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засгийн хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, ирсэн үү? Бат-Ирээдүйн Анар Эдийн засгийн хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга ирээгүй байна. Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Сангийн яамныхан хаачсан юм бэ? Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Дэлгэржаргал Хөрөнгө оруулалтын газрын дарга ирээгүй байна. Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Мөнхдэлгэр Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын судалгааны хэлтсийн дарга, Чандмань Эдийн засгийн хөгжлийн яамны Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Өлзийсайхан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын шинжээч нарын бүрэлдэхүүнтэй өнөөдрийн хэлэлцүүлгийг хийнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64.1.2-т Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэж, санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын хамт Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодод хүргүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын Байнгын хороод 2025 оны 9 дүгээр сарын 29, 30, 10 дугаар сарын 1-ний өдрүүдэд хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хийж, санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор хүргүүлсэн байна. Байнгын хороодоос

ирүүлсэн санал, дүгнэлтийг танилцуулна. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Очирбат. Микрофоныг нээе.

Г.Очирбат: Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 9 дүгээр сарын 15, 16, 17-ны өдрүүдийн нэгдсэн хуралдаанаар явуулж, 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсөв болон Эдийн засгийн байнгын хороо бусад Байнгын хороонд тус тус шилжүүлсэн.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд 2025 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцлээ. Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэхэд Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

Х.Ганхуяг: Очирбат гишүүнд баярлалаа. БОХХАА-н байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Батжаргал танилцуулна. Батжаргал гишүүний микрофоныг нээе.

Ж.Батжаргал: Байнгын хороодын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 9 дүгээр сарын 15, 17, 18-ны өдрүүдэд нэгдсэн хуралдаанаар хийж, 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсөв болон Эдийн засгийн байнгын хороо, бусад Байнгын хороодод шилжүүлсэн.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар дээрх хуулийн

төслийн 2 дахь хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь хэсэгт заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцлээ. Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй бөгөөд хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэндээ хүргүүлсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 27, 28 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх БОХХАА-н байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Х.Ганхуяг: Батжаргал гишүүнд баярлалаа. ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Номин танилцуулна. Номин гишүүний микрофоныг өгөөрэй.

Ч.Номин: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 9 дүгээр сарын 15, 17, 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо, бусад байнгын хороонд шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг эрхэлсэн асуудлынхаа хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64.1.2-т заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл, заалт бүрээр хэлэлцлээ. Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2026 оны төсвийн төсөөллийн, төсвийн багцад хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрхийг хангалттай хангагдуулсан холбогдолтой асуултыг асууж, төлөвлөж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмж, технологийн шийдэл, хүний нөөц, эрхийг нь баталгаажуулахад чиглэсэн шалгуур үзүүлэлтүүдийг оруулах боломж байгаа эсэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчаас асуулт асууж, хариулт авсан болно. Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Х.Ганхуяг: Номин гишүүнд баярлалаа. ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар, Даваагийн Цогтбаатар гишүүний микрофон өгье.

Да.Цогтбаатар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2025 оны 9 дүгээр сарын 15, 17, 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо, бусад Байнгын хороодод шилжүүлсэн.

Хууль зүйн байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг 2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь хэсэгт заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй бөгөөд Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг төрийн албан хаагчийн орон тоо, хаагчдын орон тоог 9 хувиар бууруулах шийдвэрийн хэрэгжилт, улсын төсвийн урсгал зардлыг бууруулснаар шүүх болон, шүүхийн болон хууль зүйн салбарын байгууллагуудын үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Ганхуяг: Цогтбаатар гишүүнд баярлалаа. Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганзориг танилцуулна.

П.Ганзориг: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 9 дүгээр сарын 15, 17, 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо, бусад Байнгын хороонд шилжүүлсэн.

Өргөдлийн байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалтын дагуу хуулийн төслийг хэлэлцлээ.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээг 1,8 тэрбум төгрөгөөр бууруулж, 31,6 их наяд байхаар төсөлд тусгасан бөгөөд орлогоо нэмэгдүүлэх боломжтой эсэх талаар, Төсвийн тогтвортой

байдлын тухай хуульд нэгдсэн төсвийн урсгал зардлын хэмжээ дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байхаар заасан. Гэвч Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлд төсвийн урсгал зардлыг бууруулж, дотоодын нийт бүтээгдэхүүний 24 хувиас хэтрэхгүй байна гэсэн шаардлагуудын улмаас багш нарын цалин хөлс, ахмадуудын тэтгэврийг нэмэгдүүлэх боломжгүй тохиолдолд уг хязгаарыг 26 хувь болгон нэмэгдүүлэх боломжтой эсэх талаар, Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төслийг хэлэлцэх үеэр инфляцын түвшин 6 хувь байна гэж тооцсон боловч өнөөдрийн байдлаар 9-өөс 10 хувь байгааг ирэх онд хэдэн хувь байхаар төсөөлж байгаа, мөн Монгол Улсын Засгийн газраас 2026 оныг Боловсролыг дэмжих жил болгон зарласан бөгөөд энэ хүрээнд багш, эмч, эмнэлгийн ажилтан нарын нийгмийн баталгааг хангах, цалин хөлс нэмэгдүүлэх ямар арга хэмжээ авч ажиллах талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлд төсвийн урсгал зардлыг бууруулж, дотоодын нийт бүтээгдэхүүний 25 хувиас хэтрүүлэхгүй байна гэсэн боловч нөгөө талд жил бүр цалин хөлсийг нэмнэ гэсэн заалт байгаа ч ялгавартайгаар хуулийн заалтын хэрэгжүүлэлтийг хангаж байгаа талаар, цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж нэмэгдүүлэх нь инфляцад нөлөөлөх гол хүчин зүйл биш бөгөөд төсвийн бодлогын орон зайг хязгаарлаж байгаа 200 гаруй хууль, 1000 гаруй заалтаас олон нийтэд нөлөөлөхүйц ямар заалт хасах боломжтой эсэх, төрийн албан хаагчдын 9 хувийг цомхотгохоос үүдэн эдийн засгийн, эдийн засаг агших талаар хийсэн тооцоо судалгааны талаар, 2025 оныг дуустал инфляцын түвшнийг хэдэн хувиар тооцож байгаа талаар хууль санаачлагч болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, хариулт авсан болно. Хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулах үед Монгол Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 27-гоос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Х.Ганхуяг: Ганзориг гишүүнд баярлалаа. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Найдалаа танилцуулна.

Б.Найдалаа: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 9 дүгээр сарын 15, 17, 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо, бусад байнгын хороодод шилжүүлсэн.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64.1.2 дахь хэсэгт заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа Засгийн газраас 2026 оныг боловсролын болон хүний хөгжлийг дэмжих жил болгон зарлаж, тэргүүлэх чиглэлээр тусган багш, ажилчдын цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулна гэсэн боловч төсөв мөнгө тавигдаагүй байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат Монгол Улсын 2026 оны төлөвлөгөөнд төсвийн урсгал зардлыг бууруулж, дотоодын нийт бүтээгдэхүүний 24 хувиас хэтрүүлэхгүй байна гэснийг өөрчилж, 25, 26 хувь болж нэмэгдүүлэх боломжтой эсэх талаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, хариулт авсан болно. Хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа зарчмын зөрүүтэй нэг санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг, Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт та бүхэнд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо.

Х.Ганхуяг: Найдалаа гишүүнд баярлалаа. Байнгын хороодын санал, дүгнэлтийг танилцуулж дууслаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд хуулийн төсөл 2 зүйлтэй. Гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж болно. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Ганбаатар гишүүн, Цогтбаатар гишүүнээр тасаллаа. Ганбаатар гишүүнд микрофон өгье.

Г.Ганбаатар: Би ч нэг их айхтар асуулт ч юу байх вэ дээ нэг санал хэлдэг юм уу. Ер нь ингээд хэдүүлээ энэ нэг энэ жилийн улсын төсөв, төсвийн төсөөлөл энэ хэлэлцэх гэж нээрээ гурилдаж байна. Эрх баригч намын энэ намын даргын сонгуультай холбоотойгоор энэ байгаа байдлаа үнэхээр хар л даа. Өглөө 11 цагт эхлэх байсан энэ хамтарсан хурал одоо 16 цаг болж байна шүү дээ. Хайран цаг биш үү, энэ олон хүмүүсийг хүлээлгээд Байнгын хорооны даргаа.

Нөгөө талд нь энэ чинь төсвийн төсөөлөл, 26 оныхоо энэ гол юмаа ярихад Эдийн засгийн хөгжлийн сайд нь байхгүй, энд өнөөдөр яг энэ хуралд 54 гишүүн ирэх ёстой, одоо ингээд хар л даа тэнд 3, тэнд 3, 6, энэ 10 гаруйнхан гишүүн л сууж байна шүү дээ. Тэгээд 54 гишүүнийг яаж нэг хуруу дарсан болж, ирцийг нь оруулсан болчихоод, хэлэлцэх гээд байгаа юм уу. Хэдүүлээ аягүй чухал хариуцлагатай юм ярьж байгаа шүү дээ. Энэ улс орны төсөв юу байгаа билээ, яаж бүрдэж байгаа билээ, эдийн засгийн нөхцөл байдал ямар байгаа билээ. Гэтэл нэг иймэрхүү маягаар нэг хэлэлцсэн болоод ийм хариуцлагагүй хандах юм уу? Улсын Их Хурал гэдэг байгууллага хууль батлах, төсөв батлах 2 үндсэн чиг үүрэгтэй.

Тэгээд энд нэг зүйлийг хэлъе. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс өчигдөр, үндсэндээ өнөөдөр Засгийн газар луу нэг албан тоот явсан байх ёстой. Энэ төсвөө буцааж татаж авч чамбайруул гээд. 5 гол зүйл Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс төсвийн ажлын хэсгийн дүгнэлт гарсан юм, 5 гол зүйл байгаа юм. 1 дүгээрт нь энэ алдагдалгүй төсөв батлах бодлогын зорилтоосоо ухарсан, тэр нь 1,3 их наядын алдагдалтай төсөв орж ирсэн гэж. 2 дугаарт нь төсвийн төсөл нь Төсвийн тухай хуульд нийцээгүй. Техник, эдийн засгийн үндэслэгээ болон батлагдсан зураг төсөвгүй 630 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт байна гэсэн. 3 дугаарт нь төсвийн төсөл нь дунд болон богино хугацааны хөгжлийн төлөвлөгөөнд үндэслээгүй, 579 арга хэмжээний 127 нь 2026 оны Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байна гэсэн. 4 дүгээрт нь төсвийн төсөл нь нийгмийн хүлээлт, шаардлагад нийцээгүй. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудал, иргэд олон нийтийн хэрэгцээ шаардлагад ерөөсөө хариулт болж чадаагүй. Ялангуяа эрүүл мэнд, боловсролын салбарт ажиллаж байгаа 122 мянган ажилчин, албан хаагчдын нийгмийн асуудал, цалингийн, цалин болон бусад асуудлыг дорвитой шийдэх дээр ямар ч энэ төсвийн төсөл дээр өөрчлөлт байсангүй гэж. 5 дахь асуудал нь төсвийн төсөв, төсвийн хүрээний мэдэгдэл, төслийн дагалдах тооцоо, судалгаа хангалтгүй байна гэж. Өөрөөр хэлбэл одоо ингээд авч байгаа үнийн индексийн таамаглал нь Монголбанкны инфляцын зорилт, таамаглалтай хэрхэн уялдсан нь тодорхойгүй гээд эдгээр 5 гол үндэслэлээр Ардчилсан намын бүлгээс энэхүү төсвийн 26 оныхоо төсвийн төслийг яаралтай татан авч, чамбайруулахыг Засгийн газарт чиглэл болгосон байгаа. Тэгэхлээр энэ асуудлыг одоо бид хэлэлцэх нь зөв үү?

Тэгээд сүүлд нь нэг зүйлийг хэлъе. Өчигдөр бид Ардчилсан намын бүлэг Монголбанкны мэдээллийг сонсоод, Монголбанкны валютын нөөц 5,9 тэрбум гээд байж байхад улс төрийн зорилгоор та бүхэн Монголбанкны валютын сан хоосорсон, ерөөсөө төлбөрийн тооцоогүй боллоо гээд иймэрхүү юмнуудаа болихгүй бол энэ чөлөөт эдийн засаг гэдэг чинь сенсацаар хомсдол үүсэж байдаг эд шүү. Ингээд баахан улс төрийн зорилгоор та нар ингээд энд тэнд ингээд талцаад мэдэгдэл хийсээр байтал чинь энэ улс орон чинь та нарын хөлд сүйрлээ.

Энэ шатахууны хомсдол үүсвэл, валютын нөөц огцом эрэлт нь ихэсвэл хэн хариуцлага хүлээх юм бэ? Тэгээд иймэрхүү хариуцлагагүй байдлаа болиоч гэдгийг энэ ташрамд та бүхэнд хэлмээр байна. Арай дэндүү байна шүү нээрээ. Их Хурлынхаа энэ чуулган түрүүн баасан гарагт хуралдаж чадаагүй. Энэ төсвийн, ер нь Байнгын хороодынхоо хуралдаж байгаа эд нар байдлыг хар л даа. Манай Их Хурлын гишүүд ч гэсэн та нар өөрсдөдөө дүгнэлт хийх хэрэгтэй. Нийтлэг Монголын ард түмний эрх ашгийн төлөө гэж тангараг өргөсөн.../минут дуусав/

Х.Ганхуяг: 1 минут сунгаад өгье.

Г.Ганбаатар: Манай Их Хурлын гишүүд ч гэсэн нээрээ дүгнэлт хийх хэрэгтэй. Бид нийтлэг улс орныхоо эрх ашиг, Монголын ард түмний төлөө гэж тангараг өргөсөн болохоос биш улс төрийн нам дахь аль нэг фракцын төлөө гэж тангараг өргөөгүй шүү. Та бүхний энэ байгаа байдал чинь тангаргаасаа няцаж байгаатай адилхан шүү. Энэ бүгдийг нэг бодооч, ухаараач гэж та бүхнээс хүсэх байна.

Х.Ганхуяг: Үг хэлчихсэн, үг хэлчихлээ. Цогтбаатар гишүүний микрофон өгье. Хэн, Тэргүүн шадар сайд ирчихсэн байна шүү.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Төсвийн төсөөллийн тухай хуулийг бид хэлэлцэх гээд сууж байгаа. Сая Учрал сайд сая орж ирсэн байна. Баярлалаа. Соёлын сайд, Эрчим хүчний сайд 2 л сууж байна даа энд. Тэгээд энэ 2-оос тооцоолол асууя гэхээр чинь төсвийн хүрээ, төсвийн төсөөллөө та хоёр Сангийн сайд голчилж ярих юман дээр та хоёроос асуугаад та хоёр хариулна гэхэд би итгэхгүй байна. Сая Байнгын хорооны дарга өөрөө Дэгийн тухай хууль уншиж танилцуулсан. Төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуух асуулт байвал гэж байгаад нэр авсан. Энэ дотор чинь Соёлын сайд, Эрчим хүчний сайд, сая Учрал сайд орж ирлээ. Бусад нь төсвийн ерөнхийлөн захирагч байгаа юм уу? Энэ хүмүүс очиж ажлаа хийвэл бараг илүү үр дүнтэй юм шиг байх юм.

Одоо Чойжилсүрэн сайд өвөл боллоо, дахиад л нөгөө тог хязгаарлах уу, үгүй юү, эрчим хүчний доголдлоо яах вэ гэдэг асуудлаа ярих ёстой байтал өнөөдөржингөө л ордонд эргэлдээд өнжчихлөө. Бид яг нөгөө урдах, урдах ажлаа хийхгүй бол одоо мэдэхгүй энэ ажлыг л лав би гайхаад байна. Асуух асуулт асуух гэхээр чинь энэ хариуцсан Сангийн сайд хүртэл алга байна шүү дээ. Хууль дээр чинь төсвийн ерөнхийлөн захирагчаас асууна л гэж байгаа шүү дээ. Монгол Улсын төсвийн хамаг асуудлыг Ерөнхий сайдын Сангийн сайд нь л хариуцна биз дээ. Тэгээд асуух гэхээр байхгүй юм чинь одоо юугаа асуух вэ.

Х.Ганхуяг: Сангийн сайдыг дуудаарай. Номин гишүүн.

Ч.Номин: Би одоо энд дандаа төрийн албан хаагчид байгаа учраас төрийн албан хаагчидтай холбоотой асуултыг асууна. Энэ Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэлд өгсөн энэ Тогтвортой байдлын зөвлөлөөс өгсөн дүгнэлт дээр нэг ийм зүйл гарч ирж байна л даа. Энэ 2025 оны 9 дүгээр сарын 1-нд legalinfo дээр тавьсан Татварын ерөнхий хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль байгаа. Энэ хуулиас шалтгаалаад энэ төсвийн хүрээний мэдэгдэлд нөлөөлөх нөлөөллийг Сангийн яамнаас гаргасан тооцооллоор ойролцоогоор 4 их наяд төгрөгийн нөлөөлөл үзүүлнэ гээд тооцоолол гаргачихсан. Энэ нь дотоодын нийт бүтээгдэхүүний 3-аас 4 хувьтай дүйцэхүйц, цаашлаад энэ хэмжээгээрээ 2027 онд алдагдал нэмэгдэх ийм боломжтой байна.

Тэгээд энэ цаашдаа энэ төсвийн тэнцлийн тусгай шаардлагуудыг хангахгүй болох гэж байна гэдэг ийм дүгнэлт өгсөн байна. Тэгээд зөрчигдөхөөр байна гэсэн ийм дүгнэлт байна. Тэгэхээр одоо бид өнөөдөр ингээд батлаад явчихдаг. Гэтэл яг дараа жил өдийд яг ялгаагүй бүгдээрээ суугаад дахиад төсвийн хүрээнийхээ мэдэгдлийг ярилцаад байж байх уу? Бид бараг 3, 4 ярилцчихлаа шүү дээ. Тэгэхээр үүнийг юу гэж харж байгаа вэ? Энийг яаж ийм, цаанаасаа ийм дүгнэлттэй орж ирчхээд байхад чинь ийм байдлаар төсөв, төсвийн хүрээний мэдэгдэл өргөн барьж байгаа вэ гэдэг асуулт байна?

Х.Ганхуяг: Учрал сайдын микрофоныг өгье.

Н.Учрал: Төрийн ажил тасралтгүй явах зарчимтай. Тийм учраас хуулийнхаа хүрээнд цаг хугацаандаа төсвийн хүрээ, төсвийн төсөөлөл, ирэх оны төсвийг өргөн мэдүүлээд хэлэлцээд явж байгаа. 5 жилийн чиглэлийг ч гэсэн 10 дугаар сарын 31-ний өмнө өргөн мэдүүлнэ. 10 дугаар сарын 15-нд Засгийн газарт танилцуулгаар

ингээд яг хуулийнхаа хугацаанд Засгийн газрын ажил тогтвортой явагдаж байгаа гэдгийг би хэлэх ёстой. Тэгэхээр энэ улс төржилтийн дунд улс эх орныхоо талаар сөрөг мэдээ мэдээллийг олон улсад ингэж болчимгүйгээр ярьж байх нь зохисгүй. Тийм учраас өчигдөр ч гэсэн нийгмээр яригдаад байгаа асуудлууд дээр бид анхааралтай ажиглах ёстой. Инфляц 8,8 хувьтай байгаа. Монголбанкны интервал хэмжээндээ ороод явж байгаа. Экспорт сэргэсэн, валютын нөөц 5,8 тэрбум доллартой байгаа, 25 оны 6 сарын байдлаар 5,2 байсан, 24 оны эцэст 5,5 л байсан. Хэн нэгэн зохиогоод хэлчхээд байгаа тоо биш.

Тийм учраас Монголбанкнаас энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах ёстой. Энэ оны, ирэх оны төсвийн төсөөлөл, төсвийн хүрээг өргөн мэдүүлэхдээ бид яг орон зайг бий болгох чиглэлээр сая татварын шинэчлэл хийе гэж зорьсон. Олон улсын валютын сангийн 25 оны 4 дүгээр сарын тайланд хөгжиж байгаа орнуудын тэнцвэржүүлсэн орлого нийт нэрлэсэн Дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа бол 5 жилийн дунджаар 26 орчим хувьтай л байгаа. Тэгэхээр бид энэ хувьд нийцүүлэх буюу цаашаа татварын шинэчлэл хийх, төрийн оролцоог бууруулах, хувийн хэвшлийг дэмжих зорилгоор яг 2024 онд нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн тэнцвэржүүлсэн орлогын харьцаа 37 хувь байсныг ирэх онд буюу 2026 онд 30,9, 27 онд 29, 28 онд 28,2 хувь болгож үе шаттай бууруулахаар оруулж ирсэн. Нэг ёсондоо орлого нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүнийх нь харьцаа гэсэн үг. Тэгэхээр энэ харьцааг бий болгож байгаа нь татварын реформ хийхэд тодорхой орон зайг үүсгэж байна гэж хэлж болно.

Дээрээс нь энэ Татварын хуультай холбогдуулаад олон нийтийн хэлэлцүүлэг эхэлсэн байгаа. Энэ 4 хуульд өөрчлөлт орно. Нэг шууд шийдэх гээд байгаа асуудал биш. Тэгэхээр үүний өмнө энэ орон зайг бий болгоод, түүн дотроо татварын шинэчлэл хийх энэ орон зайг гаргаж авсан. Дээрээс нь хувийн хэвшлийг дэмжих, төрийн оролцоог бууруулах чиглэлээр хууль эрх зүйн шинэчлэлийг хийж байна. Тэгээд шатлалтай ажлууд явагдаж байна л гэдгийг хэлье.

Х.Ганхуяг: Номин гишүүн тодруулъя.

Ч.Номин: Учрал сайдаа би нөгөө яг энэ дүгнэлт дээр л уншаад байгаа юм л даа. Энэ орон зайгаа гаргаагүй байна, 2027 онд төсвийн тэнцлийн тусгай шаардлагууд зөрчигдөхөөр байна буюу 4 их наяд төгрөгийг тооцоогүй байна гээд орж ирчхээд байгаа юм. Та болохоор болчихсон байна гээд, би бас ингээд уншихаар тэр нь гарч ирэхгүй байгаа байхгүй юу. Тэгээд яг ямар тоон дээр зөрөөтэй гарч ирээд, би олж харахгүй эсвэл Тогтвортой байдлын зөвлөл ийм дүгнэлт гаргаад байгаа юм бол? Эндээс ингээд харахаар тоонуудыг нь ингээд харахаар Дотоодын нийт бүтээгдэхүүний 3-аас 4 хувийн тэнцэх хэмжээний алдагдлаар нэмэгдэх нь байна. Энэ нь ингээд тогтвортой байдлыг чинь зөрчөөд байна гэдэг ийм дүгнэлт гарчхаад байгаа байхгүй юу.

Х.Ганхуяг: Учрал сайдын микрофоныг өгье.

Н.Учрал: Үгүй ээ яах вэ зүгээр ер нь энэ удаагийн төсвийн хүрээ, ирэх оны төсвийн төсөөлөл бол өөрөө Төсвийн тогтвортой байдлын хуулийн тусгай шаардлагыг бүрэн хангасан, орлого, зарлага нь аль алиныг нь бууруулсан, тэнцвэржүүлсэн орлого тэр GDP-ийн харьцааг одоо 37 хувь болчихоод байгааг 30 руу буулгаад үе шатлалтайгаар 28 онд 28 хүртэл буулгана гэж байгаа бол өөрөө тэр орон зайг л бий болгох гэж байгаа Засгийн газрын бодлого.

Дээрээс нь үүнийг дагалдуулаад Татварын багц хууль. Ингээд энэ эдийн засгийн эрх чөлөө, хөрөнгө оруулалт, зөвшөөрөл, мэдэгдэл гээд энэ хувийн хэвшлийг дэмжих бодлого эрх зүйн реформын хүрээнд хэрэгжинэ. Ингээд төсвийн сахилга бат, хариуцлагыг өндөр барьсан. Дээрээс нь тэр алдагдал гээд байгаа чинь ч гэсэн яг үнэндээ эдийн засгийн ийм агшиж байгаа үед мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлээд, хувийн хэвшлийн ажлын байрыг хадгалъя л гэдэг зарчим. Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн үүн дээр нэмэлт тайлбар хэлэх байх.

Х.Ганхуяг: Номин гишүүн тодруулах юм уу? Номин гишүүний микрофон өгье.

Ч.Номин: Таны наадах хариултыг сонсоод нөгөө талын яг орж ирсэн төсвийг харахаар болохоор 1,4 их наядын татварын орлого нэмэгдүүлнэ гэж орж ирээд байгаа юм. Тэгээд энэ нь та сая хэллээ, хувийн хэвшлийг дэмжих, илүү чөлөөт зах зээлийг дэмжих талаасаа орж ирнэ гээд. Тоон үзүүлэлтийг чинь харахаар болохоор ААНОАТ-ыг 450 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлнэ буюу 7 хувиар нэмэгдүүлнэ, нийгмийн даатгалын шимтгэлийг 706 тэрбумаар нэмэгдүүлнэ, 11 хувиар нэмэгдүүлнэ, НӨАТ-ыг бүүр нөгөө буцаан олголтынхоо 5 хувийг өгснөөсөө гадна 811 тэрбумаар нэмэгдүүлнэ буюу 11 хувиар нэмэгдүүлж өсгөж орлогоо нэмэгдүүлнэ гээд 2 зөрөөтэй мэдээлэл гарч ирээд байгаа байхгүй. Нэг талдаа татвараараа орон зайгаа, татварын бааз сууриа нэмэгдүүлээд орон зайгаа тэлээд явах гээд байгаа буюу 4 их наядын юу гэдэг юм ийм алдагдал хүлээх боломжтойгоор тайлбарлаад байдаг. Нөгөө талдаа болохоор төсвийн яг 2026 он дээр чинь болохоор.../минут дуусав/

Х.Ганхуяг: Учрал сайд хариулах уу? Учрал сайд.

Н.Учрал: Үгүй ээ яах вэ эдийн засгийн өсөлт 5,7-д хүрнэ гэхээр эдийн засаг өсөж байгаа хувьд ийм номинал дүнгээрээ өсөж байгаа нь байх л үзэгдэл гэж хэлэх ёстой. Зүгээр юу ярих гээд байна гэхээр наад энэ төсвийн хүрээ энэ чинь бол ирэх төсвийн бодлого. Тэгэхээр энэ бодлого өөрөө энэ тусгай шаардлагуудыгаа хангаад, энэ орон зайгаа бий болгох руугаа л чиглэх ёстой шүү дээ. Тийм учраас бид энэ эдийн засгийн бодлогоо өөрөө энэ төрийн оролцоог бууруулахад илүү анхаарал хандуулсан байхгүй юу. Тэгэхээр ирэх онд зээл гэхэд л 1,7, 1,9 байгаа шүү дээ их наяд хэрэглэнэ. Тэгтэл тэрний 1,4 дээр нь л алдагдал тавьж байгаа чинь хувийн хэвшлээ дэмжиж байгаа л бодлого байхгүй юу. Тэрнээс биш шууд ингээд аваад ороод ирвэл энд чинь хувийн хэвшлийн ажлын байраа яаж хадгалах вэ гэдэг асуудал яригдана. Тэгэхдээ өмнөх батлагдсан төсвийн хүрээнээс аль аль нь орлого, зарлага нь.../минут дуусав/

Х.Ганхуяг: Булгантуяа гишүүн.

Х.Булгантуяа: Би нэг ийм хэдэн зүйлийг асуух гэсэн юм. 1 дүгээрт Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн дагуу хуулийн 14.4-ийн дагуу энэ сарын 10 сарын 30-наас өмнө Засгийн газар 5 жилийнхээ хөгжлийн төлөвлөгөөг оруулж ирэх ёстой, үндсэн чиглэлийн төслийг оруулж ирэх ёстой. Үүнтэй уг нь бол уялдуулж ирэх жилийн төсөв орж ирэх ёстой байсан. Тэгээд энэ цаг хугацааны хувьд ийм алдаатай байгаа учраас, асуудалтай байгаа учраас яг үнэнийг хэлэхэд чуулганы эхний төсвийн эхний танилцуулга дээр С.Ганбаатар гишүүн хэлж байсан энэ бол

алдаатай болоод байна, 5 жилийн төлөвлөгөөгөө батлуулалгүйгээр та бүхэн төсвөө өргөн барьж байгаа нь алдаатай байна гээд. Яах вэ энэ 2 хуулийн дунд алдаатай цаг хугацааны ийм зөрчилтэй зүйл байж болно. Тэгэхдээ төсөв 9 сарын 1-нд өргөн баригдана гэдэг хуулийг Тэмүүлэн нарын гишүүд 2024 оны хаврын чуулганаар Улсын Их Хурлаар батлуулж байсан. Тэрнээс хойш жил гаруй хугацаанд болоход энэ 2 хуулийн цаг хугацааны зөрчлийг арилгах юмыг та бүхэн маань хийчихгүй яасан юм бэ? Одоо энэ чинь ингээд Улсын Их Хурал үргэлжлүүлээд хэлэлцээд явахаар Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуультайгаа нийцээгүй төсвийг бид ингээд батлаад яваад байгаа ч юм шиг ийм эвгүй байдалд Улсын Их Хурлыг ч оруулаад, Засгийн газар ч өөрснөө орчхож байгаа юм биш үү 1 дүгээрт?

2 дугаарт энэ 5 дахь өдөр Төсвийн байнгын хорооны гишүүд ээ, Төсвийн байнгын хорооны дарга Улсын Их Хурлын нэгдсэн чуулган дээр төсвийн 2 дугаар хэлэлцүүлэг явуулсан талаарх санал, дүгнэлтийг уншиж танилцуулна. Сая Байнгын хороодын бүгдийнх нь санал, дүгнэлтийг уншиж танилцууллаа. Ингээд 5 дахь өдөр ер нь энэ төсвөө шууд үргэлжлүүлээд энэ чигээр нь Улсын Их Хурал хүлээж аваад хэлэлцэх үү, үгүй юү гэдэг санал хураалт явах гэж байна. Бид энэ том зохицуулалтуудыг хийгээд, төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдлийг хийх энэ тэр бол орон зай аягүй хүнд болно. Энийг манай Төсвийн байнгын хорооны дарга ч гэсэн сайн мэдэж байгаа. Нэлээн тооцооллуудыг гаргасан байна лээ. Тэгэхээр бидний хувьд нэг ялангуяа мэргэжлийн Байнгын хороо маань үүн дээрээ нэг нэлээн мэргэжлийн байдлаар байхгүй бол энэ чигээр нь хүлээгээд авчихвал хэдүүлээ хөрөнгө оруулалтуудаас хасаад ингээд оруулах бол их хэцүү болно шүү дээ.

Жилийн төлөвлөгөөгөө бид чинь урсгал зардлаа нэлээн хязгаарлачихсан жилийн төлөвлөгөөгөө баталсан. Засгийн газар хэлэхдээ та нар өөрсдөө ингэж баталж өгсөн шүү дээ гээд байгаа юм. Бид тэр тоог санаанаасаа зохиож тавиагүй байхгүй юу. Та бүхэн өөрснөө Улсын Их Хуралд өргөн бариад л, ирэх жилийнхээ төсвийг ингэж хийнэ гээд л тэгэхээр нь тэгвэл болох юм байлгүй дээ, тэгээд төрийн албан хаагчдынхаа цалингийнхаа нэмэгдлийг тооцсон юм байлгүй дээ гээд л бид чинь баталсан шүү дээ. Тэгсэн чинь өөрснөө оруулж ирээд батлуулчхангуутаа эцэс сүүлд нь та нар ийм юм баталж өгсөн болохоор л бид төрийн албан хаагчдын цалинг нэмж чадахгүй байна гэж ингэж урвуулан яриад байх утгагүй байх л гэж бодож байна. Банканд

Тэгээд зүгээр яг сүүлийн хэд хоног төсөв өргөн барьснаас хойш, төсөв хэлэлцсэнээс хойш ордны гадаа байнга жагсаал болж байна төрийн албан хаагчдын. Энэ хаа очиж даамжрахыг нь бид сайн мэдэхгүй байна. Яах вэ ингээд төсөв баталдгаараа батална гээд машиндаад бид баталчихвал болж байна. Тэгэхдээ ирэх хавар энэ та бүхэн маань инфляц энэ бүх юм чинь одоо 8,8 хувь бараг 9 хувьтай байхад ирэх жил иргэдийн кармагаас өөрөөр хэлбэл энэ хэмжээгээр орлого нь буурна л гэсэн үг шүү дээ. Тэгэхээр тэр хэмжээгээр зардал нэмэгдэнэ л гэсэн үг. Тэгэхээр энэ бүгдийг нөгөө талдаа хүмүүсийн нуруун дээр үүрүүлэх л нэг ийм хэцүү юм руу оруулах гээд байх юм Улсын Их Хурлыг.

Тэгээд энэ нэг зөрчлүүдээ арилгахын төлөө жоохон юм хийчихгүй дээ бүхэл бүтэн мэргэжлийн яам байж байж. Учрал сайд саяхан томилогдсон болохоор тэрүүнийг хийж амжаагүй байх. Тэгэхдээ энэ Эдийн засаг, хөгжлийн яаман дээр жоохон сэтгэл дундуур байна шүү. Энэ бүгдийг та бүхэн, та нарын нөгөө яам

болгонд байдаг Библи шиг өөр өөрийнх нь юу гэж хууль гэж байдаг. Сангийн яаман дээр бол Төсвийн тухай хууль. Энэ хууль нь ингээд өөрсдийн чинь хууль нь зөрчигдчихөөд байхад, асуудал үүсчхээд байхад засчихгүй дээ, одоо тэгээд энийг яах вэ?

Х.Ганхуяг: Учрал сайд хариулах уу?

Н.Учрал: Улсын Их Хурал Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг өмнөх үндсэн чиглэлийн баримт бичиг дуусгавар болох хугацаанаас 1 сарын өмнө батална гэдэг ийм хуультай. 21 онд батлагдсан 5 жилийн үндсэн чиглэл 26 оны 1 сарын 1-нд дуусгавар болно. Тэгэхээр 1 сарын өмнө батална гэхээр бид 10 дугаар сарын 31 сүүлийн хугацаа Их Хуралд өргөн мэдүүлэх. Тэгээд хуулийнхаа хүрээнд л явж байгаа. Тэгэхээр зун чуулган хуралдуулаад энэ хуулийг өөрчилнө гэдэг хэцүү л дээ. Тэгээд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр нь өөрөө 5 жилийн үндсэн чиглэлтэй уялдсан. Ингээд 24 оны парламентын сонгуулийн дараа бид Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрөө баталсан. Энэ 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр 3 намын мөрийн хөтөлбөрийг нэгтгэсэн, уялдуулсан ийм 4 жилийн хөтөлбөр. Энэ 4 жилийн хөтөлбөрт суурилсан улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө баталсан. Энэ жилийн төлөвлөгөөндөө бид төсвөө нийцүүлж байгаа. Тэгэхээр яг хуулийн асуудал гэвэл яг ийм л байгаа юм.

Тийм учраас 5 жилийн чиглэлийг түрүүлж батална ч гэдэг юм уу, энэ угаасаа зарчмын хувьд буруу л даа. 5 жилийн чиглэл чинь өөрөө л 4 жилийн хөтөлбөрөө уялдуулаад л явах ёстой шүү дээ. Улсын жилийн төлөвлөгөө гээд угаасаа л байгаа байхгүй юу. Ингээд улсын жилийн төлөвлөгөөнд тэр урсгал зардлыг 24 хувь дотроо барина гэдэг чинь жилийн төлөвлөгөөнд туссан. Дээрээс нь энэ удаагийн энэ төсвийн хүрээ, төсвийн бодлого өөрөө сахилга бат, хариуцлагыг хатуу барьсан, тусгай шаардлагыг хатуу барьсан юм гэдгийг эдийн засагчид ч тэр, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл ч тэр дүгнэлтдээ оруулсан байна лээ. Бид өмнө нь батлагдсан төсвийн хүрээнээсээ орлого, зарлагыг нь аль алиныг нь бууруулсан, тэр хувийн хэвшилд орон зайг нь хадгалж өгсөн. Ингээд улсын төсвөөр бүх төслийг санхүүжүүлэхгүй учраас Төр, хувийн хэвшлийн түншлэлийнхээ хуулийг одоо дагалдуулж бариад, жилийн төлөвлөгөөнд тусгасан төслүүдээ хэрэгжүүлбэл гэж ингэж л зорьсон. Харьцангуй нэлээн ийм чамбай боловсруулагдсан төсвийн бодлого, төсвийн хүрээ л гэж би үзэж байгаа юм.

Тийм учраас яах вэ зүгээр Булгантуяа дарга бол нөхцөл байдлыг сайн мэдэж байгаа. Өөрөө Сангийн дэд сайд байсан хүн. Ер нь энэнээс илүү шахаж явна гэж хэцүү. Тэгээд би бол амаараа хэзээ ч урсгал зардлаа нэмэгдүүлэхгүй бол би цалин нэмж чадахгүй байна гэж хэлээгүй. Урсгалаа нэмэхгүй, нэмбэл наадхын чинь цаана тэр инфляц өдөөгөөд энэ төсвийн бодлого чинь өөрөө буруудна. Тийм учраас энэ урсгалыг нэмэх бололцоогүй л гэж үзэж байгаа. Тийм учраас нөгөө энэ улс төрийн том шуурган дотор нөгөө Булгантуяа дарга ч биднийг шүүмжлэх гээд, бид ч танд нэг хариулт хэлээд ингэж яахын оронд бүгдээрээ ажиллаад л тэгээд л явуулъя. Би хуулиар хүлээсэн эрхээ л, бүрэн эрхийнхээ хүрээнд ажиллаад л, өмнөх ажлаа хийгээд ингээд л явж байгаа юм. Тийм учраас энэ төсөв талаасаа л бүгдээрээ асуудалд хандъя.

Х.Ганхуяг: Булгантуяа гишүүн тодруулъя.

Х.Булгантуяа: Учрал сайдаа үүн дээр улс төржих гээд байгаадаа биш л дээ. Ингээд 26 он гэдэг би зүгээр ингэж харсан юм. Хамгийн их реформ хийх боломжтой он цаг. Яг сонгуулийн дараагийн жил жоохон хэцүү байдаг. Яагаад гэвэл бүх сайдууд шинэ байдаг. Эхний жилийн төсвийг ер нь бараг сайдууд ч боловсруулж чаддаггүй юм. Яамны хэдэн газрын дарга, мэргэжилтнүүд сууж байгаад хамгийн сүүлд Сангийн яамныхан нийлүүлээд л өргөн барьчихдаг. 2 дахь жилийн төсөв хамгийн хариуцлагатай төсөв болдог. Яагаад гэвэл тэр үед Их Хурлын гишүүд ч бүгдээрээ аягүй туршлагатай парламентчид болчихдог. Дээрээс нь нэмээд салбарын сайдууд ч гэсэндээ мундаг болчихдог тэр үед. Тэгээд тэр үед хамгийн их реформ амтагдсан, үнэртсэн тийм төсөв орж ирдэг. Би тийм төсөв орж ирэх болов уу гэсэн асар их хүлээлттэй байсан яг үнэнийг хэлэхэд.

Тэгээд мэдээж яах вэ төсвийн тусгай шаардлага хангасан гэдэг бол би ер нь төсвийн тусгай шаардлага хангаагүй төсвөө сүүлийн хэдэн жил өргөн барьсныг ер нь бараг санахгүй байна. Чойжилсүрэн сайдын үед ч өргөн барьж байсан, Хүрэлбаатар сайдын үед ч өргөн барьж байсан, Жавхлан сайдын үед ч өргөн барина. Энийг.../минут дуусав/

Х.Ганхуяг: Нэмээд 1 минут.

Х.Булгантуяа: Одоо зүгээр үүсээд байгаа нөхцөл байдлыг хэдүүлээ яах вэ гэдэг дээрээ л ярья. Энэ бол улс төр биш. Багш нар, эмч нар, төрийн албан хаагчид бухимдалтай байгаа нь үнэн. Цалин нь бага байгаа нь бас үнэн. Тэгээд ирэх жил хэдүүлээ зарим нэг юмнаасаа танаж хасаад, хэрвээ инфляц чинь ийм хэмжээтэй байвал энэ хүмүүсийн амьжиргааг дэмжих дээр бид яах вэ? Цалин нэмчихвэл инфляц нэмэгдэнэ гэдэг юмаа одоо хэдүүлээ нэг жоохон больё тэгэх үү? Яагаад гэвэл наад 1 их наядын тоног төхөөрөмж чинь 400, 500 тэрбум шууд ирэх жил гадагшаа гадаад валют болоод гарах юм байна лээ шүү дээ. Дээрээс нь нэмээд энэ олон зам чинь дээрээс нь нэмээд инфляцыг ерөөсөө өдөөхгүй юу тийм ээ? Бидэнд болохоороо төрийн албан хаагчдад цалин болохоороо инфляц өдөөгдөнө, хөрөнгө оруулалт бол инфляц өдөөхгүй гэдэг тийм утгагүй зүйрлэл байж болохгүй шүү дээ. Харин хүний хэрэглээний 60 орчим хувь нь л байдаг. Бусад нь яг Монгол хүний хэрэглээ чинь ихэнх нь ингээд л нэг мах гурил, түлээ нүүрс, наад захын хэрэглээндээ явж байгаа болохоос биш.../минут дуусав/

Х.Ганхуяг: Жавхлан сайд.

Б.Жавхлан: Булгантуяа сайдын асуулт дээр нэмэлт мэдээлэл өгье. Төсвийн реформ нэг жил хийх боломжгүй, үеийн үед л бид алхам алхмаар хийгээд явж байдаг. 2026 оны төсөв илүү онцлогтой орж ирсэн шүү. Ер нь төсвийн тэлэлтийг хязгаарлах, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг мөн зэрэгцээд дэмжинэ. Хувийн хэвшлийг дэмжих ийм онцлог бүхий төсөв орж ирсэн. Энэнтэй хэн ч маргахгүй байх гэж бодож байна.

5 дахь өдөр харин хоёрдугаар хэлэлцүүлгийн талаар та их зөв сэдэв хөндлөө. Хэрвээ алдагдалгүй төсөв байх ёстой энэ тэр гээд попорч яваад буцаачихвал 1,3 их наядаар хөрөнгө оруулалтаа танаж хаяад, бид ямар ч эдийн засгийн өсөлтөө дэмжих багажгүй болоод, ингэж буцаж орж ирээд, тэгээд цалин, тэтгэвэр, тэтгэмж гээд ямар ч орон зай нь, бодлогын орон зай үлдэхгүй улам л хүнд байдал руу орно. Тийм учраас хэдүүлээ ямар ч байсан төсвөө дэмжээд,

хэлэлцээд, ажлын хэсгээ байгуулаад, ажлын хэсгийнхээ хэлэлцэх явцдаа харин ямар.../минут дуусав/

Х.Ганхуяг: Нэмээд, Жавхлан сайд нэмэлт минут.

Б.Жавхлан: Тийм учраас хэдүүлээ ажлын хэсгээ байгуулаад, ямар боломжууд байна, та хамгийн их илүү мэдээлэлтэй байгаа хүн, өнгөрсөн онд төсөв баталж байх үед тогтоолоор үүрэг өгөөд, бид таны ширээн дээр ийм, ийм хуулиар ийм, ийм төсөв аль хэдийн хуваарилагдчихсан байдаг шүү. Энийг эрэмбэлээд нааш нь, цааш нь болгож байж, бодлогын орон зай цаашдаа гарах нь гээд ингээд танилцуулсан байгаа. Тэрийгээ одоо хэдүүлээ эргэж хараад, алийг нь эрэмбэлж, алийг нь хасах вэ, алин дээр нь бодлогын орон зай гаргах вэ гэдгийгээ дахиад ярилцаад явахад болохгүй юм байхгүй л дээ. Энэ нь ч бараг илүү их дардан, арай шулуун зам нь болов уу гэж ингэж харж байгаа.

Инфляцын хувьд шууд хэрэглээн дээр очдог цалин бол өдөөгчөөрөө хамаагүй илүү хүчтэй байлгүй яах вэ. Бид баахан байшин барилга, сургууль, цэцэрлэг барьчихаад тоног, төхөөрөмжгүй хоосон сууж байж чадахгүй. Тэгэхээр тэр талд бас л асуудал үүсдэг. Тийм учраас хамгийн боломжит хэмжээгээрээ яамнууд, ялангуяа зөөлөн дэд бүтцийн.../минут дуусав/

Х.Ганхуяг: Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Байхгүй байна. Бусад Байнгын хороон дээр гаргасан зарчмын зөрүүтэй 1 санал байгаа. Мөнхтуяа гишүүний гаргасан санал байна. Саналыг нь та бүхэнд уншиж танилцуулъя. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027, 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд дэх нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ 2026 онд “31,6 их наяд төгрөг гэснийг “490 тэрбум” төгрөгөөр, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 2026 онд “32,9 их наяд төгрөг” гэснийг “490 тэрбум” төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, үүнтэй уялдуулан холбогдох эдийн засгийн үндсэн үзүүлэлт болон харгалзах дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээнд өөрчлөлт оруулах гэсэн ийм санал байгаа юм.

Энэ дээр тайлбар байхгүй байна. Асуулт асууж болохгүй дэгээрэй. Энэ гишүүн өөрөө л энийгээ тайлбарлах дэгтэй. Тийм, дэгээрээ болохгүй. Энэ тийм, шууд санал хураана гэсэн үг. Тэгэхдээ ер нь бол байхгүй эх үүсвэрийг нэмэгдүүлээд, зарлагыг бас нэмэгдүүлнэ гэхихсэн ийм санал байгаа. Чойжилсүрэн сайдын микрофоныг өгье.

Б.Чойжилсүрэн: Ганхуяг даргаа ийм байгаа, наана чинь төсвийн Засгийн барьсан төсвийг Их Хурал дээр нэмэгдүүлж болохгүй гээд бүр Үндсэн хуулийн заалтад орчихсон байхгүй юу. Тэгэхээр санал хурааж болохгүй шүү дээ Үндсэн хуультай.

Х.Ганхуяг: Энэ чинь төсвийн хүрээн дээр ингээд санал гаргачихсан байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр санал хураахаас өөр арга байхгүй. Нийгмийн бодлогын байнгын хороон дээр санал хураагаад дэмжээгүй байгаа. Тэгээд ер нь дэмжих боломжгүй ийм санал байгаа. Сая Чойжилсүрэн сайдын хэлж байгаа ч үндэслэлтэй байгаа юм. Энэ бол Үндсэн хуулийн зөрчилтэй байгаа шүү. Тэгээд

санал хураалт, санал хураалтад бэлдье. Тайлбар өгөөрэй, Гандулам зөвлөх тайлбар өгчих.

Б.Гандулам: Төсвийн байнгын хороо Гандулам. Энэ Мөнхтуяа гишүүний гаргасан санал бол Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороон дээр хураагдаад, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй санал байгаа. Энэ Төсвийн хүрээний мэдэгдэл буюу Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64.1.2-ын дагуу явагдана. Энд бол 2 дахь хэлэлцүүлгээр Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд Төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, гаргасан саналынхаа үндэслэлийг тайлбарлан үг хэлж болно гэсэн байгаа. Байнгын хороод зарчмын зөрүүтэй санал тус бүрээр санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томьёолж, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг санал, дүгнэлтийн хамт Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ гэсний дагуу Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос санал, дүгнэлтийнхээ хамт Мөнхтуяа гишүүний гаргасан энэ саналыг манай Байнгын хороонд хүргүүлсэн байгаа. Энийг тухайн өөрийнхөө үндсэн Байнгын хороо болох Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороон дээр дэмжээгүй санал. Манай Байнгын хороон дээр энэ саналыг дахин хураалгаад, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулах ийм дэгтэй байгаа.

Х.Ганхуяг: Гандулам зөвлөхийн микрофоныг өгье.

Б.Гандулам: Гандулам тайлбарыг өгье. Би Үндсэн хуулийн заалтаас, Үндсэн хуульд улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно. Ингэхдээ Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно гэсэн заалттай. Одоо яг бидний хэлэлцэж байгаа асуудал бол Төсвийн хүрээний мэдэгдэл байгаа. Төсвийн хүрээний мэдэгдэл бол Дэгийн тухай хуулийн 64.2 дээр зайлшгүй тэр Байнгын хороон дээр хураагдчихсан саналыг манай Байнгын хороо хураагаад, цааш нь аваад явах байхгүй юу.

Х.Ганхуяг: Гишүүний саналаар нь санал хураана гэсэн үг. Тийм. Тэгэхээр зүгээр цөмөөрөө тийм, Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяагийн гаргасан санал. Би дахиад уншаад өгье. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027, 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд дэх нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ 2026 онд “31,6 их наяд төгрөг” гэснийг “490 тэрбум төгрөгөөр”, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 2026 онд “32,9 их наяд төгрөг” гэснийг “490 тэрбум” төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, үүнтэй уялдуулан холбогдох эдийн засгийн үзүүлэлт болон харгалзах дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээнд өөрчлөлт оруулах гээд гишүүний гаргасан санал байна. Санал хураалтад бэлдье. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяа. Гишүүний саналаар. Санал хураалтад бэлдье, хуруугаа хийгээрэй, санал хураалтад бэлдээрэй. Энэ одоо яг юугаар байна вэ? Гарч ирэхгүй байна даа. Санал хураалт. Санал хураалтад оролцсон гишүүдийн 97 хувь нь дэмжиж, 35-аас 34 гишүүн татгалзсан байна. Энэ санал дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна

уу? Байхгүй байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдааны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Заяабал танилцуулна.

16.09 цаг

Хамтарсан хуралдаан дууслаа. Байнгын хорооны гишүүд болон ажлын хэсэгт баярлалаа. Үргэлжлүүлээд Төсвийн байнгын хороо хуралдана.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА